



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ТӨМӨРБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/100

Төмөрбулаг сум

**Г Бог малын мялзан өвчнөөс урьдчилан
сэргийлэх дархлаажуулалтын ажлыг
зохион байгуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.6, Аймгийн засаг даргын А/509, Аймгийн мал эмнэлгийн газрын даргын А/39 дэх тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн дархлаажуулалтын арга хэмжээнд 2024 онд бойжсон хурга ишиг, эрсдэлтэй байж болзошгүй хонин сүргийг хамруулах ажлыг 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн 20 хоногийн хугацаанд зохион байгуулахыг мал эмнэлгийн тасагт даалгасугай.

2. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн дархлаажуулалтын арга хэмжээг батлагдсан хуваарийн дагуу, технологит хугацаанд шуурхай зохион байгуулахыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн захирал нарт үүрэг болгосугай.

3. Дархлаажуулалтын арга хэмжээг зохион байгуулахад ашиглах шатах тослох материалаар ханган ажиллахыг ЗДТГ-н нягтлан бодогч /Х.Даваачулуун/-д хариуцуулсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ЗДТГ-ын дарга /Г.Нямханд/-д үүрэг болгосугай.

ДАРГА



А.МӨНХ-ЭРДЭНЭ